



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1139

Хажуу шинэ үс

Техникийн хяналтын үзлэг, тээврийн
хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг
шинэчлэн явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 заалтыг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 17 дугаар зүйлийн 17.1, 17.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуй нэгж, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, албан татвар, төлбөр хураалт, техникийн хяналтын үзлэгийг 2022 оны 05 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, албан татвар төлбөр хураах, техникийн хяналтын үзлэг тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

3. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлд хамрагдалт, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар орон нутгийн зам ашигласны төлөлт, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан байдалд хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилгуулж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), ажлын хэсгийн ахлагч (Д.Сарангэрэл) нарт үүрэг болгосугай.

4. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийг шинэчилсэн бүртгэл татвар хураалтын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж ажилласан дүн мэдээг улирал тутам танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Сарангэрэл)-д үүрэг болгосугай.


5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/25 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

Засаг даргын 2022 оны 14 дугаар сарын 14-ны
өдрийн 14/14 тоот захирамжийн
Хавсралт



Автотээвар болон өөрөө явагч хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, албан татвар,
төлбөр хураах, техникийн хяналтын үзлэг тооллого явуулах комиссын
бүрэлдэхүүн

Комиссын дарга	Д.Сарангэрэл (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга	Д.Алтансаргай (Татварын улсын байцаагч)
Гишүүдэд	Н.Ганбат (Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Төгөлдөр (1 дүгээр багийн Засаг дарга)
	Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Наранбаатар (3 дугаар багийн Засаг дарга)
	Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)
	Э.Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч)
	М.Бат-Эрдэнэ (Хэсгийн Цагдаа)